



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Канад Улсын Лаурел сан хооронд 2015 оны 08 дугаар сарын 12-ны өдөр, Архангай аймгийн Эрүүл мэндийн газар, Канад улсын Лаурел сан хооронд 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр тус тус байгуулсан Хамтын ажиллагааны гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080442



Эрүүл мэндийн сайдын
2018 оны 03 сарын 26-ны өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харъяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хью Макферсон Парсонс Hugh Macpherson Parsons	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Архангай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг	ГЭ0001882	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2018-03-28 2018-04-08 /12 хоног/
2.	Франсис Чи Хунг Ло Francis Chi Hung Law	Канад Улс	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг Архангай Аймгийн Нэгдсэн Эмнэлэг	ГЭ0001883	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2018-03-28 2018-04-08 /12 хоног/